



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/144

Чингис хот

Газар өмчлөх эрхийг дуусгавар болгож,  
газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.5, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, Хэрлэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 09 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Довжоогийн Батболдын гаргасан хүсэлтийн дагуу 221604350 нэгж талбарын дугаар бүхий Хэрлэн сумын 1 дүгээр баг, Л-41 тоот хаягт байрлах 702 м<sup>2</sup> газрын газар өмчлөх эрхийг дуусгавар болгосугай.

2. Хэрлэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 9 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтын 1 дэх хэсэгт заасан газар болон дээрх иргэний газар өмчлөх эрх дуусгавар болгосон газрыг нэгтгэн Хэрлэн сумын 1 дүгээр баг Тагнуулын хэлтсийн урд талд байрлах 1442 м<sup>2</sup> газрыг аймгийн Тагнуулын хэлтэст эзэмшүүлсүгэй.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг аймгийн Тагнуулын хэлтэс /Д.Төгсөө/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2008 оны 257 дугаар захирамжийн хавсралтын 22 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

6. Энэхүү захирамжийг аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлж холбогдох бүртгэлийг хийлгэхийг иргэн Д.Батболдод үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА